

## **ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮНЭТ ЦААСЫГ БАРЬЦААЛАХ ТУХАЙ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар харилцагчийн бусдын өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлийг түүний эзэмшил дэх үнэт цаасаар хангуулах, гадаад, дотоодын харилцагч иргэн, хуулийн этгээд нь брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компанид барьцаа хөрөнгө байршуулсны үндсэн дээр хувьцаа зээлэн авч, арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны арилжаанд оролцох, зээлийн барьцаанд тусгаарлуулах, үнэт цаасны барьцааны тухай мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, барьцааны эрх үүссэнийг нийтэд мэдэгдэх, үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор барьцаалагч, барьцаалуулагч, гуравдагч этгээдийн хооронд үүссэн харилцааг тус тус зохицуулна.

1.2. Энэхүү журмын харилцаанд Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг дагаж мөрднө.

1.3. Энэхүү журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамрагдаагүй хязгаарлагдмал хариуцлагатай компани, хаалттай хувьцаат компанийн үнэт цаас, зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрөөгүй бусад төрлийн үнэт цаасыг барьцаалахтай холбоотой харилцааг зохицуулахгүй болно.

### **Хоёр. Журмын нэр томъёоны тодорхойлолт**

2.1. Энэхүү журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан нэр томъёог хэрэглэхээс гадна дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

2.1.1. “Барьцаа” гэж бусдын өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлийг хангахаар гэрээ байгуулж, тусгаарлуулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.8-д заасан үнэт цаасыг аар ойлгох;

2.1.2. “Маржин” гэж брокерийн компанийн зээлдүүлсэн үнэт цаасны анхны үнийн дүн болон харилцагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд учирсан хохирлыг брокерийн компаниас төлөхөөр хүлээгдэж буй үнийн дүнгийн хоорондын зөрүүг;

2.1.3. “Хөрөнгө оруулалтын багц” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-т заасан үнэт цаасны төрлөөс нээлттэй компанийн хувьцаа, компанийн өрийн хэргэсэл болон Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.19-д заасан Засгийн газрын үнэт цааснаас бүрдсэн багц хөрөнгийг;

2.1.4. “Барьцааны данс” гэж брокерийн компанид барьцаа хөрөнгө байршуулсан дансыг;

Formatted: Font: Font color: Black, Not Highlight

Formatted: Font: Font color: Black, Not Highlight

Formatted: Font: Font color: Black, Mongolian (Cyrillic), Not Highlight

Formatted: Font: Font color: Black, Not Highlight

2.1.5. “Харилцагч” гэж брокерийн компанид данс нээлгэсэн, тус компаниар үйлчлүүлж буй иргэн, хуулийн этгээдийг;

2.1.6. “Үнэт цаас зээлдүүлэх” гэж харилцагч данс нээлгэсэн брокерийн компанид барьцаа хөрөнгө байршуулсны үндсэн дээр үнэт цаас зээлээр авч, арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны арилжаанд оролцох ажиллагааг;

2.1.7. “Зах зээлийг үүсгэгч” гэж үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зарчимд тулгуурлан тодорхой үнэт цаасыг худалдах, худалдан авах захиалга өгч, арилжааг идэвхжүүлэх үүрэг бүхий брокер, дилерийн компанийг;

2.1.8. “Мэргэжлийн хөрөнгө оруулагч” гэж Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас тодорхойлсон хөрөнгө оруулалтын сан, хэджи сан, тэтгэврийн сан, арилжааны даатгалын компани, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй банк, брокер, дилерийн компанийг;

2.1.9. “Барьцаалагч” гэж үүрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор болон бүрэн гүйцэтгээгүй тохиолдолд түүний эзэмшиж буй үнэт цаасаар үүргийн гүйцэтгэлээ хангуулах баталгааг эдлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийг;

2.1.10. “Барьцаалуулагч” гэж үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон өөрийн эзэмшлийн үнэт цаасаар барьцаалагчийн өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа гаргасан иргэн, хуулийн этгээдийг;

2.1.114. “Цахим мэдээллийн сан” гэж Улсын бүртгэлийн байгууллагын хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санг;

2.1.125. “Баталгаажилт” гэж барьцааны эрх гуравдагч этгээдийн өмнө хүчин төгөлдөр байх, барьцааны зүйлээс шаардлагаа хангуулах барьцаалагчийн эрхийн дараалалын тогтоосон баталгаажилтууныг;

~~2.1.6. “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42.3, 45 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг эрхэлж буй этгээдийг;~~

2.1.13. “Үнэт цаасыг тусгаарлах” гэж хууль хяналтын байгууллага болон төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, мөн харилцагчийн хүсэлтээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь түүний дансанд байршиж буй ~~ан~~ үнэт цаасны шилжилтийг бүрэн болон хэсэгчилэн тодорхой хугацаанд зогсоохыг ~~хн~~;

2.1.14. “Барьцааны мэдэгдэл” гэж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас тогтоосон маягтын дагуу барьцаалагч эсхүл түүний төлөөлөгч үнэт цаасыг барьцаанд тавих талаар цахим мэдээллийн санд бүртгүүлэх ж буйийг.

### **Гурав. Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаа**

3.1. Харилцагч нь арилжаа эрхлэх байгууллагын арилжаанд брокерийн компаниас үнэт цаас зээлдэн оролцоходоо тусгай дансанд барьцаа хөрөнгө байршуулна.

3.2. Брокерийн компани нь харилцагчийн төлбөрийн чадвар болон маржинг тооцоолсны үндсэн дээр үнэт цаасыг зээлээр олгох дээд хэмжээг тогтоох ба барьцаа хөрөнгө нь компанийн хувьцаа болон Засгийн газрын үнэт цаас, компанийн өрийн хэрэгсэл зэрэг түргэн хөрвөх чадвартай, эрсдэлгүй үнэт цааснаас бүрдэнэ.

3.3. Барьцаанд байршуулсан нийт хөрөнгийн 70-аас доошгүй хувь нь хөрвөх чадвартай үнэт цаас, 30 хүртэлх хувь нь бэлэн мөнгөнөөс тус тус бүрдэнэ.

3.4. Брокерийн компани нь харилцагчид үнэт цаасыг зээлдүүлэхдээ барьцаанд байршуулсан нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 30 хувиар нэмэгдүүлсэн дүнгийн хязгаарт зээл олгоно.

3.5. Энэхүү журмын 3.4-т заасан үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанд зах зээлийг үүсгэгч, мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцох бөгөөд бусад иргэн, хуулийн этгээдийн хувьд тэдгээрийн барьцаа хөрөнгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээгээр үнэт цаас зээлээр олгоно.

3.6. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь барьцааны мэдэгдэлийн загварыг тогтоож, олон [нийтэд тогтмол мэдээлэх ажиллагаа](#)г гүйцэтгэх ба үнэт цаасны барьцааны бүртгэлтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн хэмжээг тус байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтооно.

3.7. Брокер нь өөрийн харилцагчийн үнэт цаас барьцаалуулах хүсэлтийг бичгээр хүлээн авсны дараа Улсын бүртгэлийн газрын цахим мэдээллийн санд бүртгүүлснээр барьцаа хөрөнгө баталгаажна.

3.8. Брокер нь цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааны талаарх мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлэх ба уг байгууллага нь барьцааны мэдэгдлийг үндэслэн үнэт цаасыг тусгаарлах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

3.9. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас үнэт цаасыг тусгаарласан тухай мэдэгдлийг үндэслэн брокер нь өөрийн харилцагчтай үнэт цаас зээлдүүлэх гэрээг байгуулах ба уг гэрээнд Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд зааснаас гадна дараах зүйлийг тусгана. Үүнд:

3.9.1. үнэт цаасыг зээлдүүлэхэд барьцаа хөрөнгийн үнэлгээнээс хамааран үнэт цаас зээлээр олгох дээд хэмжээг тогтоох аргачлал, тооцоолол;

3.9.2. үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээний хураамж, шимтгэлийн хэмжээ;

3.9.3. барьцаа хөрөнгийн үнэлгээ буурах болон барьцаалуулагч хүлээсэн үүргээ зохих ёсоор нь гүйцэтгээгүйгээс учирч болох алдагдлыг хаах, арилгах арга хэмжээ;

3.9.4. харилцагчийн төрлөөс хамааран үнэт цаас зээлдүүлэхэд тавигдах нарийвчилсан шаардлага, нөхцөл;

3.9.5. харилцагчийн барьцаа хөрөнгийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас данс тусгаарласан талаарх мэдээлэл.

3.10. Үнэт цаас зээлдүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд брокерийн компани нь энэ талаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон Улсын бүртгэлийн байгууллагын цахим мэдээллийн санд тус тус бүртгүүлнэ.

3.11. Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг эрхлэгч брокер нь тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхэд хангалттай хэмжээний хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлнэ.

3.12. Энэхүү үйл ажиллагааг эрхлэх брокер нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, бусад холбогдох журам, зааварт тусгасан шаардлага, нөхцөлийг хангасан байхаас гадна сүүлийн 3 жилийн хугацаанд үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцсон компани байна.

3.13. Харилцагч нь брокертой байгуулсан үнэт цаас зээлдүүлэх гэрээний хүрээнд зээлээр авсан хувьцааг арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдах тохиолдолд хувьцааны үнэ нь тухайн компанийн хувьцааны хаалтын ханш эсхүл нийт худалдах захиалгын дундаж үнээс доошгүй байна.

3.14. Барьцаанд байгаа үнэт цаасны хүү болон ногдол ашгийн орлого нь барьцааны зүйлд тооцогдох бөгөөд уг орлогыг захиран зарцуулах эрх нь гэрээний хугацаанд барьцаалагчийн эзэмшилд шилжинэ.

3.15. Брокерийн компани нь зөвхөн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын тусгаарлалтад байгаа үнэт цаасыг барьцаа хөрөнгийн дансанд байршуулах бөгөөд барьцаалагдсан үнэт цаасыг дахин барьцаанд байршуулан үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

#### **Дөрөв. Үнэт цаасыг зээлийн барьцаанд тавих үйл ажиллагаа**

4.1. Барьцаалуулагч нь өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг бусдын өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар зээлийн барьцаанд тусгаарлуулсан тохиолдолд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас тогтоосон барьцааны мэдэгдлийн загварын дагуу Улсын бүртгэлийн байгууллагын цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

4.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь барьцааны мэдэгдэлд дараах зүйлийг тусгана. Үүнд:

4.2.7.1. барьцаалуулагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар /гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол гадаад паспорт буюу түүнтэй адилтгах баримт бичгийн дугаар/, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, оршин байгаа газрын хаяг;

4.2.7.2. барьцаалагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, албан ёсны хаяг;

4.2.7.3. үүргийн гүйцэтгэлийг хангах үнэт цаасны нэр төрөл, тоо ширхэг;

4.2.7.4. барьцаагаар хангуулаах үүргийн гүйцэтгэлийн хугацаа, нөхцөл;

Formatted: Font: (Default) Times New Roman, 12 pt, Font color: Text 1

4.27.5. өмнө нь барьцаалж байсан бол барьцааны талаарх товч мэдээлэл, барьцаалсан огноо, гэрээний дугаар.

Formatted: Mongolian (Cyrillic)

4.38. Нэгээс дээш барьцаалагч болон барьцаалуулагчтай бол энэ журмын 4.27.1, 4.27.2-т заасан мэдээллийг холбогдох этгээд тус бүрээр тодорхой тусгана.

4.4. ~~Цахим мэдээллийн санд бүртгэгдсэн~~ Барьцааны мэдэгдэл нь цахим мэдээллийн санд бүртгэгдэж, баталгаажигдснаар нийтэд нээлттэй бөлсөн үеэ хүчин төгөлдөр болно.

4.5. Барьцаалуулагч нь цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааны талаарх мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлэх ба уг байгууллага нь барьцааны мэдэгдлийг үндэслэн үнэт цаасыг тусгаарлах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

4.5. Барьцаалуулагч нь барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацааг сунгах тухай мэдэгдлийг гаргаагүй бол цахим мэдээллийн санд бүртгүүлснээс хойш гурван жилийн хугацаанд барьцааны мэдэгдлийн бүртгэл хүчинтэй байна.

Formatted: Font: (Default) Times New Roman, 12 pt

Formatted: Font: (Default) Times New Roman, 12 pt, Bold

4.6. Энэхүү журмын 4.5-т заасан хугацаанаас өмнө барьцаалуулагч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон, үүнтэй холбогдуулан шүүхээс барьцааны зүйлийг барьцаалагч этгээдийн эзэмшилд шилжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд барьцаалагч нь барьцааны бүртгэлээс хасах тухай мэдэгдлийг гурав хоногийн дотор цахим мэдээллийн санд хүргүүлэх ба үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь цахим мэдээллийн сангаас барьцаа нь цуцлагдсан тухай мэдээллийг үндэслэн барьцаалагчийн холбогдох дансанд өмчлөх эрхийг шилжүүлнэ. дампуурах.

4.7. Барьцаалагч болон барьцуулагчийн зөвшөөрлөөр барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгах, цуцлах тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан шаардлагын дагуу гаргана.

#### **Тав. Эрсдэлийн удирдлага**

5.1. Брокерийн компани нь үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг явуулахдаа харилцагчдын санхүү, төлбөрийн чадварыг судалж үзсэний үндсэн дээр барьцаа хөрөнгийн шаардлага, маржингийн хувь хэмжээг өдөр бүр тооцоолно.

5.2. Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд тухайн брокерийн компани нь санхүүгийн болон төлбөрийн чадвар, хүний нөөцийн хувьд чадамжтай байхаас гадна холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, заавар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ханган сүүлийн 3 жилийн хугацаанд үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцсон компани байна.

5.3. Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг эрхлэх брокерийн компани нь харилцагчийн барьцаа хөрөнгө, маржингийн хэмжээг тооцоолох, төлбөрийн чадваргүй болсноос учрах эрсдэлийн түвшинг өдөр тутмын давтамжтайгаар тооцоолох мэргэшсэн эрсдэлийн албатай байна.

5.4. Энэхүү журмын 5.3-т заасан эрсдэлийн алба нь үйл ажиллагаандаа мөрдөх эрсдэлийн удирдлагын бодлоготой байх бөгөөд уг бодлогыг хэрэгжүүлэх ажиллагааг нарийвчлан заасан дотоод журмыг боловсруулна.

5.5. Брокерийн компани нь энэхүү журмын 3.3-т заасан бэлэн мөнгөний барьцаа хөрөнгөтэй холбоотой дараах үйл ажиллагааг явуулж болно. Үүнд:

5.5.1. Брокерийн компани нь харилцагчтай байгуулах гэрээнд заасан бол тухайн харилцагч зээлээр авсан үнэт цаасаа буцаан олгох хүртэл барьцаанд байгаа бэлэн мөнгөнд хөрвөх чадвартай хувьцаа, Засгийн газар болон компанийн өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж болно;

5.5.2. Энэхүү журмын 5.5.1-д заасан барьцаа хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотойгоор харилцагчдад учрах хохирлыг тухайн брокерийн компани хариуцна;

5.5.3. Брокерийн компани нь тухайн харилцагчтай үнэт цаас зээлдүүлэх гэрээ байгуулахаас өмнө уг хөрөнгө оруулалтын ажиллагаанаас учирч болох эрсдэлийн талаарх бүрэн мэдээллийг өгсөн байна;

5.5.4 Брокерийн компани нь харилцагч бүрт шударга, эрх тэгш хандах зарчмыг баримтлан үнэт цаасыг зээлдүүлэх бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө оруулалтын багцтай байна;

5.6. Брокерийн компани нь харилцагчдын барьцаа хөрөнгийг барьцааны дансанд байршуулж, өөрийн компанийн хөрөнгөнөөс тусад нь байлгах үүрэгтэй.

5.7. Брокерийн компани нь өөрийн хөрөнгөөр үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанд оролцон зээлээр хувьцаа авах тохиолдолд энэхүү журмын 5.3-д заасан эрсдэлийн албанаас гадна тусдаа хөрөнгө оруулалтын нэгж байгуулах ба уг нэгж нь тухайн компанийн зээлээр хувьцаа аван арилжаанд оролцох ажиллагааг удирдан, харилцагчдад үзүүлэх үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанаас тусад нь зохион байгуулна.

**ж-бөглө**/Ярилцах/

### **Зургаа. Мэдээллийг олон нийтэд хүргэх**

6.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны тусгаарлалтад байгаа барьцаа хөрөнгийн талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийт танилцах бололцоог хангаж ажиллана.

6.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь барьцаа хөрөнгийн бүрдүүлбэрт өөрчлөлт орсон тухай бүр олон нийтэд мэдээллэх ба тусгаарлалтад буй үнэт цаасны хэмжээ, үнэ, чөлөөлөгдөх хугацаа зэргийг тодорхой заана.

6.3. Үнэт цаасны тусгаарлалтад байгаа барьцаа хөрөнгө нь барьцааны эрх үүсэнийг олон нийтэд мэдээллэх зорилготой ба барьцааны гэрээний агуулгатай холбоотой мэдээллийг холбогдох этгээд барьцаалагч, эсхүл барьцаалуулагчаас тодруулга хүсч болно.

### **Долоо. Хороонд мэдээлэл хүргүүлэх**

7.1. Брокерийн компани нь Хорооноос баталсан “Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн нэгдсэн журам”-аас гадна дараах мэдээллийг Хороонд улирал болон сар тутам ирүүлнэ. Үүнд:

7.1.1. Брокерийн харилцагчтай байгуулсан үнэт цаас зээлдүүлэх гэрээтэй холбоотой мэдээлэл;

7.1.2. Брокерийн үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, түүнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор;

7.1.3. Брокерийн компанитай үнэт цаас зээлдүүлэх гэрээ байгуулсан харилцагч төлбөрийн чадваргүй болсноос учирсан хохирлыг барагдуулсан талаарх мэдээлэл;

7.1.4. Брокерийн компани болон харилцагчдын хооронд байгуулсан гэрээний хүрээнд барьцаа хөрөнгийн өмчлөх эрхийн асуудал шүүх, хяналтын байгууллагаар шийдэгдэхээр болсон бол уг ажиллагааны талаарх мэдээлэл;

7.1.5. Брокерийн компани нь өөрөө үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанд оролцон зээлээр хувьцаа авсан тухай бүр уг ажиллагааны талаарх мэдээлэл.

#### **Найм. Хорооны хяналт, шалгалт**

8.1. Хороо нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын үнэт цаасны тусгаарлалтад байгаа барьцаа хөрөнгийг бүртгэх, уг барьцааны талаар олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хуульд заасан хариуцлага ногдуулна.

8.2. Хороо нь брокерийн компани үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ журам болон холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг баримталж байгаа эсэх, үнэт цаас зээлдүүлэхтэй холбоотойгоор харилцагч болон компанид учрах эрсдэлийг бууруулахын тулд эрсдэлийн алба байгуулан барьцаа хөрөнгө, маржинг өдөр бүр тооцоолж буй эсэхэд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хуульд заасан хариуцлага ногдуулна.

~~9.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь Цэцэгийн мэдээллийн санд үнэн зөв мэдээлэл оруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээ зорчсоноос бусдад хохирол учирсан тохиолдолд хохирлыг бүрэн мэдээлэл оруулсан буруутай этгээд хариуцна, нөхөн төлнө.~~

#### **Ес. Тусгаарлалтаас чөлөөлөх**

9.1. Барьцаалуулагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд зээлийн барьцаанд тусгаарлагдсан үнэт цаасыг барьцаалагчийн хүсэлт эсхүл гэрээ дүгнэсэн актыг үндэслэн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага байгууллага барьцаалуулагчийн дансанд ажлын 3 хоногийн дотор буцаан шилжүүлнэ.

Formatted: Mongolian (Cyrillic)

9.2. Хэрэв барьцаалуулагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцаанд тусгаарлагдсан үнэт цаасыг гэрээ дүгнэсэн акт эсхүл Шүүхийн шийдвэр болон бусад баримтыг эзрэнг үндэслэн барьцаалагчийн холбогдох дансанд шилжүүлнэ.

#### **Арав. Хариуцлага**

10.1. Хороо нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, брокерийн компанийн үнэт цаас зээлдүүлэх, барьцаа хөрөнгийг үнэт цаасны тусгаарлалтад бүртгэх, олон нийтэд мэдээллэхтэй холбоотой үйл ажиллагаанд энэ журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

10.2. Барьцаалагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч барьцааны мэдэгдэлийг цахим мэдээллийн санд бүртгүүлээгүйгээс үүргийн гүйцэтгэл хангуулах дараалал өөрчлөгдөх, түүний улмаас үүсэх аливаа эрсдэлийг тухайн этгээд бүрэн өөрөө хариуцана.

~oOo~